

**МОНГОЛ АМАН ЗОХИОЛ, УРАН ЗОХИОЛЫН
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ АСУУДАЛД**

С. Дулам *

Аливаа бичгийн уран зохиолын үүсэл хөгжилд тухайн ард түмний аман билгийн соёл чухал үйлдэлтэй байдаг төдийгүй, бичгийн уран зохиол нь эргээд аман уламжлалт соёлдоо гүн гүнзгий нөлөөлдөг. Энэхүү харилцаа холбоог судлан үзэх зайлшгүй шаардлагатай билээ.

Энэ удаа миний бие монгол аман зохиол болон бичгийн уран зохиолын хоорондын уламжлал, залгамж холбоог хэдэн зүйлээр авч үзэж, залуу судлаачдад цаашдын судалгааных нь ажилд санаа сэдэл болж мэдэх асуудлыг хөндөх гэсэн билээ. Монгол аман зохиол болон бичгийн уран зохиолын хооронд юуны өмнө төрөл зүйлийн залгамж холбоо байна. Тухайлбал, уран зохиолын гурван үндсэн төрөл уянга, туульс, жүжгийн зохиолын төрөл зүйлсийн залгамж холбоо байна.

Уянгын зохиолын хувьд монгол ардын уянгат дууны шүлэг монгол яруу найрагчдын уянгын яруу найрагт нөлөөлсөн жишээнүүд элбэг байна. Заримдаа ардын дуу, зохиолын дууны хоорондын ялгаа нь мэдэгдэхээ больсон тохиолдол ч цөөнгүй. Хамгийн наад захын жишээг хэлэхэд, амраг сэтгэлтний зүүдний жаргал, зүрх сэтгэлийн дуулал хэмээн эндүүрдэг байсан, бидний сайн мэдэх “*Ай Нан-аа*” хэмээх дуу нь угтаа хайртай хүүгээ Манжийн хаанд цаазлуулж, цар таваг дээр бүтээлэгтэй толгойг нь тосон аваад эх нутагтаа ирж, хатан ээжээс нь чандлан нуудаг боловчиг шөнийн зүүдэндээ талийгаач хүүтэйгээ тоглон наадаж зүүдлэн сэрээд зохиосон, халхын их ноён Чин ван Ханддоржийн эмгэнэл харууслын үг [Болдбаатар 2007, 214]; [Хэрлэн, Энхмаа 2009, 4-7]¹ гэдгийг бид төдүүлэн анзаардаг билүү. Мөн түүнчлэн дөнгөж саяхны Д.Нацагдоржийн зохиосон “Цэнхэрлэн харагдана”, Д.Догсом хурцын зохиосон “Хөх торгон дээл” хэмээх дууг олон хүн ардын дуу л гэж бодсоор байгаа.

Сэдвийн хувьд аваад үзсэн ч гэсэн, монгол ардын дууны гол сэдэв болсон эцэг эхийн ачлал, элбэрэл, эх болсон газар нутгаа хайрлан санагалзах сэдэв, хүлэг сайн морь, янаг амрагийн үнэнч сэтгэлийн дуулал тэр чигээрээ монголын сонгодог болон орчин үеийн яруу найрагт уламжлан ирсэн билээ.

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Утга зохиолын тэнхим

¹ Болдбаатар Ж. “*Ай Нан-аа*” амрагийн дуу мөн үү?. МУИС-ийн НШУС-ийн эрдэм шинжилгээний бичиг, 2007, 214-р тал. Хэрлэн Л., Энхмаа Д. *Домогт дууны зуун дээж*. Хянан тохиолдуулсан С.Дулам, Улаанбаатар, 2009, 182 т.х.

Түүнээс гадна монгол аман зохиолын магтаал, ерөөл орчин үеийн уран зохиолд уламжлан эх орны тухай магтаал шүлэг, найраглал, орчин үеийн ерөөлүүд гарсан билээ. Монгол аман зохиол, сонгодог уран зохиол, орчин үеийн магтаалын нэгэн бадаг шүлгийг зэрэгцүүлэн задласхийж үзье. Уул усны уянгат магтаал дуу болох “Алтайн магтаалд”:

*Мөнх цасан эхтэй
Мөлгөр чулуун оргилтой
Өргөн түмэн хүдэр өндөр
Баян хан Алтай нутаг минь гэв гэнээ*

хэмээн аялгуулдаг байхад Равжаа хутагтын “Галбын магтаалд”:

*Элдэг цасан тэргүүнтэй [тоорцогтой]²
Элдэв цэцгийн цамцтай [тоньюгтой]³
Эрээн зүлгэн хормойтой [зөөлөн маюгтай]⁴
Эрдэм төгс орон бий.*

хэмээн шүлэглэсэн байдаг бөгөөд Ц.Дамдинсүрэнгийн “Монгол орон” дууны шүлэгт:

*Цагаан цасан малгайтай
Ногоон модон хүрэмтэй
Хөх усан хормойтой
Баян Хангайн уул минь⁵*

гэхчлэн гардаг нь заримдаа мөр, бадгаараа, заримдаа уран яруу хэрэглүүрээрээ таарч байна. Тухайлбал, эртний монгол хэл, өнөөгийн дөрвөд, захчин, торгууд, өөлд, урианхай, баяд, хотон зэрэг баруун монгол аялгуунд тархи толгойг “*толхаанэкэн*” гэж хэлдэгийг бодолцон үзвэл, Алтайн магтаал, Равжаагийн шүлэг, Дамдинсүрэн аругайн дууны үгийн эхний мөр нь “Мөнх цасан эхтэй [толгойтой]/ Элдэг цасан тэргүүнтэй/ Цагаан цасан малгайтай” буюу “Мөнх/ элдэг/ цагаан/ цасан/ эхи толгой/ тэргүүн/ малгайтай” гэсэн нөхөн сэргээлгэ гарч ирнэ. Сонирхолтой нь тэргүүн шадын цасны тодорхойлолт цаг хугацаанд үл эвдрэх шинж чанараас халуун говийн үтэрхэн хайлдаг элдэг цасан болсноо өөрийн ургаажийн өнгө зүс рүүгээ шилжсэн бол эртний монгол хэлний толгойг заадаг эх хэмээх үг нь, бичгийн хэлний толгойн хүндэтгэл *тэргүүн* болж ирснээ, наян зургаан эхт хувилбарын *тоорцогоор* дамжин малгай болж тогтсон байна. Чингэхдээ Алтайн уулсаас Галбын говь хүрч, тэндээсээ Хангайн нуруу орсон байна. Газар зүйн нэрээрээ бол “*Баян хан Алтай нутаг*” маань Галбын говиор дамжин, *Баян Хангайн уул* болжээ. Ц. Дамдинсүрэн аругайн өөр нэгэн магтаал найраглалд “*мөлгөр чулуун оргил*” маань “*мөчит дөрвөн хөлтний мөр нь гараагүй оргил, мөгөөрс нимгэн хоолойтны дуу нь хүрээгүй оргил*” болж шинэчлэгдсэн буй. Харин Равжаа хутагт, Дамдинсүрэн аругай нарын шүлэгт

*Элдэв цэцгийн цамцтай [тоньюгтой] Д.Р/
Ногоон модон хүрэмтэй Ц.Д/*

² 67 ба 86 эхтэд.

³ 67 ба 86 эхтэд. Энэ нь төвд хэлний *stod gyogs* “дээд нөмрөг, дээд хувцас” гэсэн үг. Төвд хэлний “шударга да”-г [da] “бяцхан нга”-гаар [nga] буруу тэмдэглэснээс болоод “дод-өг, тод-өг” гэж уншихын оронд “тон-өг, тон-юг” гэж өөрчлөн уншсан бололтой.

⁴ 67 ба 86 эхтэд. Энэ нь төвд хэлний *smad gyogs* “доод халхавч, доод хувцас” гэсэн үг. Энд мөн төвд хэлний “шударга да”-г [da] дагаврыг алгасч уншаад “мад-өг” гэж уншихын оронд “ма-өг, ма-юг” гэж өөрчлөн уншсан бололтой.

Эрээн зүлгэн хормойтой [зөөлөн маюгтай] Д.Р /
Хөх усан хормойтой Ц.Д/

гэсэн эн зэрэгцүүлсэн адилтгал бүхүй үлэмж ижил төстэй мөрүүд байгаа билээ. Аль ч тохиолдолд энэ нь аман зохиол, сонгодог уран зохиол, орчин үеийн уран зохиолын хэлхээ холбооны нэгэн жишээ болно гэж бодож байна. Түүгээр ч барахгүй, энэ залгамж холбоо маань дүр дүрслэлийн болон уран яруу хэрэглүүрийн төвшинд ч ийнхүү мэдэгдэж байна.

Монгол ардын зүйр цэцэн үг, мэргэн үгс нь төр ёсны сургаал, билиг болон уламжилсан жишээ олон байна. Энэ талаар манай уран зохиол судлаачид анзааралгүй өнгөрсөнгүй. Манай нэртэй аман зохиол, уран зохиол судлаач Ш.Гаадамба “Монголын нууц товчоон”- ы судалгаандаа энэ тухай дурдан гаргасан байдаг [Гаадамба 1990] ⁶. Энэ асуудлыг тусгайлан судалсны хувьд Ш.Гаадамба “Монголын нууц товчоо” монгол аман зохиол хоёрын харилцан холбогдох асуудлыг гурван зүйлээр авч үзсэн байдаг. Үүнд, нэгд, “Монголын нууц товчоонд” ардын аман зохиолын хэсэг орсон гэдгийг, хоёрт, орчин цагт уламжлан ирсэн ардын аман зохиолын зарим зүйлс эрт балар цагийн үүсэл, гаралтайг, гуравт, монгол ардын аман зохиолын дотор уламжлан ирсэн олон зүйлсийн үүсч гарсан шалтгаан нөхцөл, түүхт үнэн байдлыг одоогийн бид олж мэдэхэд тус болно” [Гаадамба 1990, 96] гэжээ. Ийнхүү “Монголын нууц товчоон”- д буй олон үг, хэллэгийг судалсантай давхардуулалгүйгээр зарим нэг үг хэллэгийг аваад үзье. “Монголын нууц товчоон”- ы 33-р зүйлд

Bodoncar buqu-qatagi aqa-yu'an qoyinaca daqaju qadaraju yabu[ju] ügüleriin aqa aqa beye teri'ütü de'el jaqatu sayin ke'eba aqa inu buqu-qatagi tere üge inu ya'un-a ber ese bolqaba [Бодончар Буху-хатаги ахынхаа хойноос дагаж, хатирч явж өгүүлэрүүн: ахаа, ахаа, бие тэргүүт, дээл захат сайн хэмээв. Ах нь тэр үгийг нь юунд ч эс болгов] [Rachewiltz 1973, 18] ⁷.

Ах нартаа хяхагдан Онон мөрний Балжун арал дээр өвсөн эмбүүл барьж суугаад, харцгайгаар шувуу бариулж идэн шар нар, бор хоногийг өнгөрөөж байсан дүүгээ ийм их төр ёсны ухаантай үг хэлнэ чинээн Буху-хатаги ах нь бодоогүй бололтой, тиймээс ч энэ үгийг хэд дахин өгүүлэхэд нь “*хариуг нь эс донгодов*”. Тэгээд олон давтасны эцэст сая “*тугаараас мөн мөн юун үг өгүүлмүй чи*” гэхэд нь “*тугаарын Түнгэлиг горхиноо бүхүй иргэн их өчүүхэн, муу сайн, тэргүүн шийр үгүй сацуун буй* [yeke ücügen mawui sayin teri'ü si'ira üge[i]'ün saca'un bui], *хялбар иргэн буй, бид тэднийг хаулая*” хэмээжээ. Тэхлээр энэ отгон хөвгүүнийг “Бодончар мунхаг” хэмээх боловч ах нараасаа тийм их мунхаг хүн биш, харин шоолон шоовдорлох утгаар өгсөн хоч- нэр гэдэг нь мэдэгдэнэ. Нөгөөтэйгүүр энд олон дахин давтан өгүүлсэн “*beye teri'ütü de'el jaqatu sayin*” хэмээх учир битүүлэг үгийн цаана эрт цагийн монголын нийгэм-улс төрийн учир холбогдолтой нэр томъёонууд илрэн гарч ирж байна. Бодончарын ахдаа тайлбарласнаар “*yeke ücügen mawui sayin teri'ü si'ira üge[i]'ün saca'un bui*” гэсэн үгс нь эртний монголчуудын овгийн ардачлалтай холбоотой нэр томъёонууд юм байна. Өөрөөр хэлбэл, нэгэн бүлэг иргэний дотор хэн нэгэн давамгайлан захирах эрх үгүй бүх насанд хүрсэн хүн өөр хоорондоо эдэлдэн шийдвэр гаргадаг байсан мэт. Эл нэр томъёонуудыг тус бүрд нь нарийвчлан

⁶ Гаадамба Ш. *Монголын нууц товчооны судлалын зарим асуудал*. Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1990, 255 т. х. 95-134, 234-254-р тал.

⁷ Rachewiltz I de. *Index to the Secret history of the Mongols*. -Bloomington, Indiana University, 1972, 347 p.

үзвэл, бас нийгмийн захирах захирагдах ёсыг хүмүүний бие бодоор жишиглэн сэтгэж, “*тэргүүн шийр үгүй*” [“*teri’ü si’iga üge[i]*” гэсэн нь толгой нь биеэ залж захирдаг био-физио-психологийн зүй жамтай адилтгасан хэрэг бололтой. Эндээс бас “хөл толгой”, “хөл толгойгоо алдах” – “эх захаа алдах” гэсэн үгс үүсч гарсан байж магад. Цаад учир зүйг нь хөөвөл Алан гоо эхийн таван хөвгүүдийн тэндэх ёсон бол өөр дотроо “их өчүүхэн, муу сайн, тэргүүн шийр” гэсэн дээр доорын ялгаа салгаа бүхүй нийгмийн байгууламжтай юм санж. Бидний бодлоор “*yeke ücügen*” гэдэг нь анхандаа насны ялгаатай холбоотой байгаад сүүлдээ ахлах захлах, удирдах жолоодуулах гэсэн утгатай болсон бололтой. Тухайлбал, Бодончарын ах нар нь их [yeke], Бодончар өөрөө өчүүхэн [ücügen] болох учраас тийн хяхагдсан буй заа. Чухам эндээс нийгмийн дээд давхрааныхныг хэлдэг “ихэс”, “ихэс дээдэс” гэдэг олон тооны үг гарсан шиг байна. Харин “муу сайн” [mawui sayin] гэдэг нь өмч хөрөнгийн байдалтай хамаатай байгаад сүүлдээ бас захирах, захирагдахын утгатай болсон байх. Өнөөгийн монгол хэлний “сайд”, “сайчуул” гэдэг үг мөн эндээс үүссэн бололтой. Учир нь Алан гоо эхийг үгүй болсон хойно ах нар дүү нэр тавуул адуусан идээгээ хуваалдахын цагт Бэлгүнүтэй, Бүгүнүтэй, Буху-хатаги, Бухату-салжи дөрвүүлээ хувааж аваад, Бодончар мунхагийг бядуу буюу [budawu buyu] муу хэмээн урагаа үл тоон юу ч эс өгсөн билээ. Энэ үгийг Игорь дө Рахевильц англи хэлээр орчуулахдаа “*he was fool and half-wit*” [тэнэг мунхаг] гэжээ. Өөрөөр хэлбэл, ах нар нь Бодончарыг “*орой гарсан, дорой төрсөн*” хэмээн дээрэлхэж, өмч хөрөнгөгүй болгож байна.

Энэ бүхнээс хамгийн чухал нь Бодончар Богдын хэлсэн “*beye teri’ütü de’el jaqatu sayin*” хэмээх учир битүүлэг үгийн чанад утга нь нийгмийн захирах, захирагдах ёсны учрыг зааж хэлсэн үг байтал өнөөгийн монгол хэлэнд “*хүн ахтай, дээл захтай*” гэсэн ёс заншил-зан суртахууны утгатай цэцэн үг болсон байна. Учир нь “*хүн ахтай, дээл захтай*” гэхэд нийгмийн анги давхаргын байдлыг гэхээсээ илүүтэй, ахчлах дүүчлэх ёс, ах захыг хүндэтгэх ёсыг ойлгох сон билээ. Бидний бодлоор Бодончар энэ үгийг хэлэхдээ урьд өмнө ард түмний дунд хэлэлцсээр ирсэн мэргэн цэцэн үгнээс санаа авсан, хэвшмэл хэлц байсан байх үндэстэй. Тийм ч учраас Буху-хатаги ах нь төдийлөн анзаарч ойшоолгүй олон дахин хэлүүлсэн байх гэмээр. Тэр үг нь “Монголын нууц товчоо” зэрэг түүхэн уран зохиолоор дамжаад, дүр дүрсээ хувирган ардын цэцэн үг болсон шиг байна. Энэ бол монгол аман зохиол, уран зохиол бие биедээ хэрхэн тусч нөлөөлдөгийн нэгэн бодтой жишээ мөн.

Энд харин нэгэн зүйлийг онцлон тэмдэглэхэд манай зарим хүмүүс, тэр ч байтугай эрдэмтэн мэргэд хүртэл Хятадын Күнзийн сургаалыг Чингис хааны сургаал мэтээр эндүүрч, ярьж бичдэгийг засч залруулах шаардлагатай. Тухайлбал, “*биеэ засаад, гэрээ зас, гэрээ засаад төрөө зас*” хэмээх үг нь угтаа Күнзийн сургаал болохоос биш, Чингис хааны билиг сургаал огтоос биш гэдгийг бодууштай. Баталгааг нь хэлье. Эртний хятадын гүн ухааны сонгодог судар “Дөрвөн бичгийн” нэгэн болох Күнзийн шавь Зэнзийн өвлүүлсэн “Их суртахуй” бичгийн долоогоос аравдугаар бөлөгт энэ тухай өгүүлсэн байдаг билээ. Тухайлбал, “... биеэ засахуй нь сэтгэлээ тэгшлэхүй дор оршмуй... биеэ засаад гэрээ төвшитгөхүй”, “гэрээ төвшитгөөд төрөө засахуй”, “төрөө засаад тэнгэрийн дор амгалан болохуй” [Зэнз 2008, 40-48]⁸ гэхчлэн иж цогцоор нь тайлдаг билээ. “Их суртахуй” бичиг бол угтаа алдарт “Таван номын” нэг “Ёслолт

⁸ Зэнз. *Их суртахуй*. Хятад хэлнээс орчуулсан М.Чимэдцэеэ, Хянан шүүсэн Ц.Базаррагчаа, Б.Лигдэн, Улаанбаатар, 2008, 67 т.х.

номын” дөчин хоёрдугаар бөлөг юм. Чухам иймээс үзэг нэгт нөхөд болон эрдэм номын шавь нартаа цаашид энэ үгийг Чингис хааны сургаал хэмээн ярьж, бичиж, амны болон бичгийн алдас хийхгүй байхыг сануулъя.

Туульсын төрөл зүйлийн тухайд В.В.Бартольд, Б.Я.Владимирцов, П.Пеллио нарын олон монголч эрдэмтэн “*Монголын нууц товчоо*”-г баатарлаг туульсын зохиолд хамааруулах, орчилт туулийн тасархай буюу хэсэг бусаг гэж үзэх саналтай байдаг байжээ. Энэ нь үнэн хэрэгтээ уг зохиолыг аман билгийн соёлтой үндэс язгуур нэгтэй гэдгийг, тэр дундаа монгол баатарлаг туульстай амин холбоотой хэмээн үзсэнтэй утга нэгэн билээ. Энэхүү санал бодрол Инжаннашийн “*Хөх судар*” романд ч нэгэн адил хамаарна гэж хэлж болно. Ер нь монгол баатарлаг туульсын дүр дүрслэлийн нөлөө манай сонгодог уран зохиолд шингэж үлдсэн нь нэлээд бий. Тухайлбал, бидний сайн мэдэх “*Чингисийн эр хоёр загалын тууж*”-д :

*Түргэн түргэн явахуй дор
Түнгэрцгийн чинээ чулуу хөдөлгөнө
Аргаар аргаар явахуй дор
Аягын чинээ чулуу хөдөлгөнө*

гэх буюу

*Их хэнгэргээ дэлдэн
Их түмэн улсаан ирүүлэв ээ
Бага хэнгэргээ дэлдэн
Бага түмэн улсаан ирүүлэв ээ*

гэх мэт туулийн тогтмол хэллэг тохиолдож байгааг [Цэрэнсодном 2002, 249]⁹ судлаачид тэмдэглэжээ.

Монгол ардын үлгэрээс эхтэй шинэ цагийн анхны үлгэр- өгүүллэгүүд 1920-1930-аад оны үед зохиогдож байсан бөгөөд тэдгээрээс уламжлан орчин цагийн өгүүллэг гарсныг судалгаа харуулж байна. Үүний тодорхой жишээ бол Ц.Дамдинсүрэнгийн “Өчүүхэн дөрвөн үлгэр”, С.Буяннэмэхийн “Уран гоо охины үлгэр” зэрэг зохиол юм. Мөн том хэлбэрийн үлгэрт туужсаас орчин цагийн тууж, роман үүсвэрлэснийг ч үргэлжилсэн үгийн том хэлбэрийн зохиолын судалгаа харуулдаг билээ.

Манай анхны театрын урлаг, жүжгийн зохиолд монгол ардын харилцаа дуу, ардын жүжиг наадмын уламжлал гүнээ нөлөөлсөн байдгийг, 1934 онд Д.Нацагдоржийн зохиосон “*Учиртай гурван толгой*” дуулалт жүжгээс тодорхой харж болно. Тэгээд ч энэ дуулалт жүжиг маань “*Үйлийн гурван толгой*” хэмээх түүх домог, түүнтэй холбоотой “Юндэн гөөгөө” хэмээх харилцаа дуунаас сэдэвлэсэн билээ. Ер нь Д.Нацагдоржийн аман зохиолын цуглуулгын дэвтрээс үзвэл, монгол зүйр, цэцэн үг, ардын дуу, бөөгийн дуудлага, өлгийн дуу, бодлогын хошин холбоо, хэл зүгшрүүлэх үг, түргэн хэллэг, ардын зан үйлийн холбооны шаггүй цуглуулгатай байсан төдийгүй, түүнээсээ санаа аван шүлэг холбоо олныг зохиодог байжээ [Хорлоо 1975, 18-22]¹⁰.

Тайз дэлгэцийн зохиол бүтээлийн тухайд Ч.Ойдовын “Далан худалч”-аас эхлээд, “Жаргалыг хүссэн Мөнхөө” драмын жүжиг, “Алтан өргөө”, “Бушхүүгийн үлгэр” гэхчлэн монгол аман зохиолоос сэдэвлэсэн жүжиг, кино арвин буй. Харин цаашид бид

⁹ Цэрэнсодном Д. *Монгол уран зохиолын товч түүх*. Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1989, 438 т. х. 2002, 479 т. х.

¹⁰ Хорлоо П. *Аман зохиол, утга зохиолын тухай*. Редактор Д.Цэдэв, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1975, 225 т.х.

магистр, докторын ажлын сэдэв болгон эл асуудлыг нарийвчлан судлах, судлуулах шаардлагатай.

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэж үзвээс

1. **Монгол аман зохиол, бичгийн уран зохиолын залгамж чанар, харилцаа холбоог төрөл зүйлийн төвшнөөс дүр дүрслэлийн төвшинд хүртэл цаашид нарийвчлан судлан шинжлэх шаардлагатай байна.**
2. **Энэхүү судалгааг бас нэгж зохиол, хувь бодгаль зохиолчийн уран бүтээлийн хувьд ч гэсэн задлан шинжилж үзвэл сонирхолтой үр дүн гарахаар байна.**
3. **Монгол аман зохиол, бичгийн уран зохиолын залгамж чанар, харилцаа холбоог судлахдаа аман билиг соёл, эртний болон сонгодог уран зохиол, орчин үеийн уран зохиол гэсэн цуваа цагийн хэлхээнд мөшгин авч үзвэл хөгжлийн зүй жам нь бүрэн бүтнээрээ, үе шат бүрээрээ тодорч ирэх боломжтой.**

ЗҮҮЛТИЙН НОМ ЗҮЙ

1. Гаадамба Ш. *Монголын нууц товчооны судлалын зарим асуудал*. Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1990, 255 т. х.
2. Болдбаатар Ж. *“Ай Нан-аа” амрагийн дуу мөн үү?*. МУИС-ийн НШУС-ийн эрдэм шинжилгээний бичиг, 2007, 214-р тал
3. Зэнз. *Их суртахуй*. Хятад хэлнээс орчуулсан М.Чимэдцэеэ, Хянан шүүсэн Ц.Базаррагчаа, Б.Лигдэн, Улаанбаатар, 2008, 67 т.х.
4. Хорлоо П. *Аман зохиол, утга зохиолын тухай*. Редактор Д.Цэдэв, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1975, 225 т.х.
5. Хэрлэн Л., Энхмаа Д. *Домогт дууны зуун дээж*. Хянан тохиолдуулсан С.Дулам, Улаанбаатар, 2009, 182 т.х.
6. Цэрэнсодном Д. *Монгол уран зохиолын товч түүх*. Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1989, 438 т. х. 2002, 479 т. х.
7. Rachewiltz I de. *Index to the Secret history of the Mongols*. -Bloomington, Indiana University, 1972, 347 p.

SUMMARY

In this article, the author examines the relationship between tradition and continuity of oral and written literature by several aspects that might be useful for the further studies by young researchers. The article details the relationship between Mongol folklore and literature.

- It is necessary to study the relationship and continuity of Mongol folklore and literature from the genres to the descriptive level.

- There will be interesting results if this study analyzes by either author or work itself.

- There will be possibility of having complete study if this study ties to oral tradition, culture and ancient and classical literatures.